



Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг байгууллагуудын 2023 оны 3 дугаар улирлын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тухай

200 байгууллага нь 2023 оны 3 дугаар улирлын байдлаар шилэн дансны цахим системд нийт 23002 мэдээлэл байршуулах ёстойгоос 92,5% буюу 21271 мэдээллийг хуулийн хугацаанд, 4,2% буюу 974 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 3,3% буюу 757 мэдээлэл огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 92,5 хувьтай гарлаа.



Диаграмм 1. Шилэн дансанд мэдээлэл байршуулалт

Мэдээлэл хугацаандаа байршуулалтыг өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулбал:



Диаграмм 2. Шилэн дансанд мэдээлэл байршуулалт

Боловсролын салбарын 79 байгууллага 3 дугаар улирлын байдлаар нийтдээ 9243 мэдээлэл байршуулах ёстойгоос 8668 мэдээллийг хуулийн хугацаанд, 290 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 20 байгууллага 285 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 93,8 хувьтай гарлаа.

Улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 52 байгууллага, хугацаа хоцроож илгээсэн 4 байгууллага, огт илгээгээгүй 15 байгууллага, хянагдахгүй 8 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 65,8 хувьтай.

Соёлын салбарын 23 байгууллага 3 дугаар улирлын байдлаар нийтдээ 2691 мэдээлэл байршуулах ёстойгоос 2518 мэдээллийг хуулийн хугацаанд, 111 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3 байгууллага 62 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 93,6 хувьтай.

Улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 16 байгууллага, хугацаа хоцроож илгээсэн 1 байгууллага, огт илгээгээгүй 4 байгууллага, хянагдахгүй 2 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 69,6 хувьтай.

Эрүүл мэндийн салбарын 20 байгууллага 3 дугаар улирлын байдлаар нийтдээ 1998 мэдээлэл байршуулах ёстойгоос 1885 мэдээллийг хуулийн хугацаанд, 103 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 байгууллага 10 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 94,3 хувьтай байна.

Улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 11 байгууллага, хугацаа хоцроож илгээсэн 1 байгууллага, огт илгээгээгүй 5 байгууллага, хянагдахгүй 3 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 55 хувьтай.

Орон нутгийн 47 байгууллага 3 дугаар улирлын байдлаар нийтдээ 5499 мэдээлэл байршуулах ёстойгоос 5036 мэдээллийг хуулийн хугацаанд, 226 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 16 байгууллага 237 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 91,6 хувьтай.

Улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 33 байгууллага, хугацаа хоцроож илгээсэн 7 байгууллага, огт илгээгээгүй 6 байгууллага, хянагдахгүй 1 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 70,2 хувьтай.

20 төрийн сан 3 дугаар улирлын байдлаар нийтдээ 2520 мэдээлэл байршуулах ёстойгоос 2203 мэдээллийг хуулийн хугацаанд, 185 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 10 байгууллага 132 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 87,4 хувьтай гарлаа.

Орон нутгийн өмчит 12 байгууллага 3 дугаар улирлын байдлаар нийтдээ 1051 мэдээлэл байршуулах ёстойгоос 961 мэдээллийг хуулийн хугацаанд, 59 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3 байгууллага 31 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 91,4 хувьтай.

Улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 7 байгууллага, хугацаа хоцроож илгээсэн 3 байгууллага, огт илгээгээгүй 1 байгууллага, бүртгүүлээгүй 1 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 58,3 хувьтай.

“Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал”-ыг сар бүр мэдээлнэ гэж заасны дагуу орон нутгийн 47 төсвийн байгууллагаас 34 байгууллага төсвийн гүйцэтгэлийн тоон мэдээллийг байршуулсан боловч түүний хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг тайлбарлаагүй, 13 байгууллага батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбарыг зарим саруудад оруулсан боловч тухайн тайлбар нь хангалтгүй байна. 20 төрийн сангаас 15 байгууллага төсвийн гүйцэтгэлийн тоон мэдээллийг байршуулсан боловч түүний хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг байршуулаагүй, 5 байгууллага төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг зарим саруудад оруулсан боловч тухайн тайлбар шалтгаан хангалтгүй байна. Орон нутгийн өмчит 12 байгууллагаас Өв эко мийт ОНӨҮГазар шилэн дансны цахим системд бүртгүүлээгүйн улмаас мэдээлэл шалгах боломжгүй, 11 байгууллага нь хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг оруулаагүй байна.

Энэ удаагийн шалгалтаар шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулалт 92,5 хувь, хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 63,8

хувь, шилэн дансны шинэ цахим системийн бүртгэлжүүлэлт 99,5 хувьтай, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасны дагуу байгууллагууд 28,771,456,170 (хорин найман тэрбум долоон зуун далан нэгэн сая дөрвөн зуун тавин зургаан мянга нэг зуун дал) төгрөгийн мэдээллийг дутуу байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлогын гүйлгээг 3 дугаар улирлын байдлаар 42,181,007,735 (дөчин хоёр тэрбум нэг зуун наян нэгэн сая долоон мянга долоон зуун гучин тав) төгрөгийг дутуу байршуулсан, төсвийн байгууллагууд батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг огт байршуулаагүй, зарим саруудад оруулсан байгууллагууд шалтгаан тайлбар хангалтгүй, шаардлагад нийцэхгүй, шалтгааныг тодорхой оруулдаггүй зэрэг зөрчлүүд нь төсвийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын админ эрхтэй хэрэглэгчид өөрийн байгууллагын шилэн дансанд байршуулах мэдээллийн нэр төрлийг бүрэн сонгож өгөөгүй, мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн хариуцлагагүй байдал мөн удирдлагын болон дотоод хяналт хангалтгүй ажиллаж байгаагаа зэргээс үүдэлтэй байна.

Байгууллагуудын цаашид анхаарах асуудлууд

1. Байгууллагын удирдлага болон дотоод хяналтын нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулж байгаа мэдээллийг бүрэн гүйцэт, үнэн зөв хуулийн хугацаанд байршуулж байгаа эсэхэд улиралд нэгээс доошгүй удаа хяналт тавих;
2. Шинэ шилэн дансны нэгдсэн цахим системд бүртгэлгүй байгаа Өв Эко мийт ОНӨҮГазрыг бүртгүүлэх, мэдээллээ бүрэн гүйцэт байршуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах;
3. Байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэл болон заавал оруулах мэдээллээ бүрэн гүйцэт сонгож оруулах;
4. Төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагууд батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг бүрэн гүйцэт байршуулах;
5. Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлогын

гүйлгээг төрийн сангийн хуулгын дагуу бүрэн гүйцэт, үнэн зөв, тухай бүр оруулж хэвших;

6. Өгсөн үүрэг даалгавар болон зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах